

Эмгэг судлалын үндэсний төвөөс байгууллагын хэрэгцээнд зориулан автомашины дулаан зогсоол түрээслэх аж ахуйн нэгжийг үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Захиалагч: Эмгэг судлалын үндэсний төв

Худалдан авах тоног, төхөөрөмж:

Эмгэг судлалын үндэсний төвөөс байгууллагын хэрэгцээнд зориулан 1 автомашины дулаан зогсоол түрээслэхтэй холбогдуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудыг үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Түрээслэх зогсоолд тавигдах шаардлага

- Дулаан, битүү зогсоол байх
- Манай байгууллагын байрлалаас 2 км-ийн радиус дотор байрлах
- Автомашины орох хаалганы өндөр 2.2 метрээс дээш байх
- 24 цагийн харуул хамгаалалт, хяналтын камертай байх
- Галын аюулгүй байдлын шаардлага хангасан байх
- Цэвэр, аюулгүй орчинтой байх
- Өвлийн улиралд тогтмол дулаан хангамжтай байх

Түрээсийн нөхцөл

- Түрээсийн төлбөрийг сар бүрээр төлнө

Үнийн саналд тусгах мэдээлэл

- Түрээсийн сарын төлбөр
- Байршлын дэлгэрэнгүй мэдээлэл
- Зогсоолын зураг болон нөхцөлийн танилцуулга
- Түрээсийн хугацаа, гэрээний нөхцөл
- Холбоо барих мэдээлэл

Санхүүжилтийн эх үүсвэр: Байгууллагын 2026 оны төсвийн хүрээнд

Нийлүүлэх хугацаа: 5-10 хоног

Үнэлгээний арга: Харьцуулах үнэ

Үнийн санал ирүүлэх хугацаа, хаяг: Үнийн саналын хугацаа: 2026 оны 05-р сарын 25-ны өдрийн 08:00 цаг хүртэл

Санал хүлээн авах цахим хаяг: emgegsudlal@gmail.com

Холбоо барих утас: 11-311733